

ХАЛХ ГОЛЫН ЯЛАЛТ, ТҮҮНИЙ ОЛОН УЛСЫН АЧ ХОЛБОГДОЛ

Ц. Пунцагноров
ШУА-ийн сурвалжлагч гишүүн

1. БНМАУ-ыг эзлэн түрэмгийлэх гэсэн Японы империализмын төлөвлөгөө

Зөвлөлт-Монголын цэрэг Халхын голын районд японы түрэмгийлэгчдийг ялсны 45 жилийн ойг Монголын хөдөлмөрчид, ах дүү зөвлөлтийн ард түмэн, дэлхийн дэвшилт хүчний хамт тэмдэглэсэн билээ.

МАХН-ын Төв Хорооноос энэ ойн тухай гаргасан тогтоолд Халхын голын ялалтын олон улсын ач холбогдлыг онцлон тэмдэглэжээ. Халхын голын ялалт бол Октябрийн социалист их хувьсгал, Монгол Ардын хувьсгалын түүхэн ололтыг хамгаалж МАХН-ын Төв Хорооны тогтоолд зааснаар БНМАУ, ЗХУ-ын эсрэг чиглэсэн фашист, милитарист «дайсны стратегийн санаархлыг таслан зогсоосон билээ».¹ Энэ ялалт Азийн төв хэсэг, Алс Дорнодод түрэмгийлэгчдийн гол замыг хааж милитарист японд хатуу сургамж болсон юм.

Япон улсын эрх баригчид японы монополист капиталын ашиг сонирхлыг илэрхийлэн Монгол оронд ноёрхлоо тогтоохыг эрт дээр үеэс санаархаж байв.

1921 оны ардын хувьсгал ялж тусгаар тогтносон Монгол Ард Улс үүссэн нь Унгерн мэтийн харгис этгээдийг ашиглан Монголын ард түмнийг колоничон боолчлох, түүний нутаг дэвсгэрийг Зөвлөлт Улсад халдан довтлох түшиц газар болгох гэсэн японы империализмын оролдлогыг тас цохисон юм.

Гэвч хувьсгалын дараах бараг хорин таван жилийн турш японы империалистууд БНМАУ-ын оршин тогтноход байнгын аюул занал учруулж байв. БНМАУ-ыг эзлэн түрэмгийлэх бодлого, төлөвлөгөөг Японы ерөнхий сайд Танакаас 1927 оны 7-р сарын 25-нд эзэн хаандаа өргөсөн нууц меморандум бичигт нарийвчлан тодорхойлсон юм. ЗХУ-тай дайн хийхийн тулд урьдчилан Монгол орныг эзлэн авах хэрэгтэй гэж Танака үзэж байв. Тэрээр «Оростой дайтахдаа бид Монголд дайны хамаг гай гамшгийг үүрүүлэх ёстой», «Эрт, орой аль нэг цагт Зөвлөлт Оростой энд байлдах болно»² гэж тэмдэглэжээ.

¹ «Үнэн», 1984.IV.27. № 101.

² «Коммунистический интернационал», 1931. № 33-34. стр. 52, 54.

1930-аад оны эхээр империалист Япон Ази тивд, тухайлбал ЗХУ, БНМАУ-ын эсрэг түрэмгий дайн дэгдээх бодлого, төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн нь Японы дотоод байдалтай холбоотой юм.

Капиталист ертөнцийг донсолгосон 1929 оны эдийн засгийн хямрал Японыг хүчтэй нэрвэсний улмаас түүний экспорт, импорт тус тус 30 хувиар буурч, хөвөн нэхмэл, машин, далайн хөлөг онгоц, ган хайлуулах үйлдвэрлэлийн хэмжээ 40—70 хувь хорогдон 1932 онд Японд 3 сая хүн ажилгүй байв. Японы хөдөлмөрчдийн аж амьдралын түвшин доройтсон нь ангийн тэмцлийг өрнүүлэв.

Дэлхийн эдийн засгийн хямрал империалист гүрнүүдийн хоорондын зөрчлийг туйлд нь хүртэл хурцатгаж эдгээр зөрчлийг шийдвэрлэхийн тулд түрэмгий дайны замыг хайх хандлагыг хүчтэй болгов.

Ази, Номхон далайн районд ноёрхохын төлөө Японтой өрсөлдөгч АНУ болон империалист бусад гүрэн Японы түрэмгийллийг дэлхийн хувьсгалт хөдөлгөөний төв—ЗХУ-ын эсрэг чиглүүлэхийг санаархаж байв.

Ийм нөхцөлд империалист Япон 1931 оны 9-р сард дайн зарлалгүй Зүүн Хойт Хятад (Манжуур)-ыг дайран довтлож богино хугацаанд түүнийг эзлэн авчээ. Ийнхүү Ази, Алс Дорнодод дэлхийн хоёрдугаар дайны анхны голомт үүсчээ.

1932 оны 3-р сард Японы түрэмгийлэгчид Манжийн Чин улсын сүүлчийн эзэн хаан агсан Пу И-гээр толгойлуулсан Манжго улс гэгчийг Зүүн Хойт Хятадын эзлэгдсэн нутаг дэвсгэрт байгуулжээ. Дараа нь БНМАУ-тай хил залгасан Барга, Өвөр Монголын нутгийг түрэмгийлэн эзлээд «Манжго»-гийн бүрэлдэхүүнд оруулжээ. Ингэснээрээ империалист Япон манай улсын хил хязгаарт шууд заналхийлэх болов.

Зүүн Хойт Хятад болон Өвөр Монголыг эзэлмэгц японы империалистууд ЗХУ, БНМАУ-ын эсрэг дайран довтлох бэлтгэлийг шуурхайлан явуулжээ. Манжго дахь Японы Квантуны армийн тоог ихээхэн нэмэгдүүлэхийн хамт япон цэргийн эрхтнүүдэд захирагдах 100 мянган хүнтэй «Манжго»-гийн армийг байгуулжээ.

Дайнд бэлтгэх зорилгоор ЗХУ, БНМАУ-ын хилийн орчим цэрэг-стратегийн чанартай төмөр зам, автомашины засмал зам тавьсны гадна Зүүн Хойт Хятадын нутагт нисэх онгоцны 60 гаруй буудал, 100 талбай ажиллуулж байв. 1932—1935 онд энэ районд телефон, цахилгаан харилцааны станцын тоог 2 дахин нэмэгдүүлж, хүчтэй радиостанц хэдэн арвыг байгуулжээ.

ЗХУ, БНМАУ-ын эсрэг үйлдэх түрэмгий дайны цэрэг-эдийн засгийн баазыг өргөтгөн юуны өмнө түлш, металлурги, химийн үйлдвэрт их хэмжээний хөрөнгө оруулав.

Түрэмгийллийн үзэл суртлын бэлтгэлийг хангахын тулд японы империализмын онолчид тус орны хүн ам «хэт олширсон», «амьдрах орчин зай шаардлагатай болсон», «хамтран дэвжих Зүүн Азийн их хүрээ нутаг» байгуулах гэх мэт үзэл санааг номлож байв.

ЗХУ, БНМАУ-ыг дайран довтлох гэсэн Японы империалистуудын бодлого төлөвлөгөөг АНУ, Англи, Франц зэрэг Өрнөдийн гүрнүүд өөгшүүлэн дэмжиж Японыг Ази, Алс Дорнодод социализм, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг цохилтын хүч болгон ашиглахыг эрмэлзэж байв.

Америкийн монополиуд Японыг цэрэг-стратегийн түүхий эдээр хангаж дайны хэрэгцээний захиалгыг биелүүлэн их ашиг хонжоо олж байв. АНУ-ын Дюпоны концерн 1932 онд Японы Мицул концернд тэсрэх шинэ бодис үйлдвэрлэх патентыг худалджээ. АНУ-ын сенатын

комиссын нэг гишүүний хэлснээр энэхүү арилжаа нь армийн хэдэн дивиз цэргийг Японд нийлүүлсэнтэй адил байжээ.³

Империалист Япон 1936 онд гитлерийн Герман, фашист Италийн хамт «Коминтерний эсрэг» түрэмгий эвсэл холбоо байгуулав. Энэхүү эвслийн гол зорилго нь ЗХУ-ын эсрэг түрэмгий дайн хийхэд оршиж байв.

Улс түмний энх тайван, аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэг бүхий олон улсын байгууллага—Лига Наций Өрнөдийн гүрний гарт орсны уршгаар Японы түрэмгийллийг зогсоож чадаагүйгээр үл барам чухамдаа империалист хүчирхийллийн замыг нээж өгсөн юм.

Олон улсын империалист харгис хүчний дэмжлэг авсан Японы милитаристууд зэвсэг хангинуулан БНМАУ-ыг илээр занан зүхэж байв. Японы эрх баригчдын үзэл бодлогыг илэрхийлэгчид Азийг «улаан шуурга», «улааны халдвараас» аврах, ЗХУ-ын Сибирь нутгийг заналхийлэх, улмаар ЗХУ, Хятадын коммунист хөдөлгөөний хооронд «гадас шаах» зорилтыг шийдвэрлэхийн тулд БНМАУ-ыг устгахыг уриалж байв.⁴

1935 оны 1-р сард Японы цэргүүд Буйр нуурын зүүн талд оршдог Халхын сүмийн районоор манай улсын нутаг дэвсгэрт цөмрөн оров. БНМАУ-ын засгийн газар мөргөлдөөнийг энх тайвны замаар шийдвэрлэхийн тулд уг районыг түр орхих тушаалыг хязгаарын цэргийн ангиудад өгч япон-манжийн талтай хэлэлцээ хийж эхэлсэн юм. 1935 оны 6-р сард төмөр замын Манжуур станцад явуулсан хэлэлцээний үеэр япон-манжийн тал Квантуны армийн төлөөлөгчийг БНМАУ-д суулгаж түүнтэй холбоо барих утасны шугам тавих гэх мэт манай улсын бүрэн эрхт байдалд халдсан зүй бус шаардлага тавьсныг Монголын тал хүлээж аваагүй юм.

Үүний хариуд Японы империалистууд 1935 оны хоёрдугаар хагас, 1936 оны эхээр 10—14 хүнтэй бүлгээс аваад батальон хүртэлх цэргийн хүчээр БНМАУ-ын эсрэг зэвсэгт өдөөн хатгалгыг олон удаа хийж хүний болон эд материалын хохирол учруулжээ. Жишээ нь: их буу, танк, нисэх онгоц бүхий япон-манжийн 500 цэрэг 1936 оны 2-р сарын 12-нд Булан дэрсийн орчмоор манай улсын хил хязгаарт халдсан боловч бут цохигдон хөөгджээ.

БНМАУ-ын засгийн газар япон-манжийн талд явуулсан эсэргүүцлийн нот бичигтээ зэвсэгт өдөөн хатгалгыг зохион байгуулсан хүмүүсийг цээрлүүлэх, учруулсан эд материалын хохиролыг нөхөхийг шаардахын хамт өдөөн хатгалгыг дахин үйлдвэл бүхий л хариуцлагыг Японы засгийн газар хүлээнэ гэдгийг мэдэгджээ.

Японы цэргийн эрхтнүүд дэлхийн олон нийтийг төөрөгдүүлэх, эзлэн түрэмгийлэх ажиллагаагаа халхавчлахын тулд хилийн будлианы гэм бурууг БНМАУ-д тохохыг оролдож «улаан монголчууд» Манжгогийн нутгийг эзлэж байна гэсэн гүжир гүтгэлгийг дэвэргэсэн юм. Япон-манжийн тал Манжуур станцад явагдсан хэлэлцээг зогсоож «асуудлыг хүч хэрэглэн шийднэ» гэж сүрдүүлэх болов.

Японы стратегийн зорилтын тухай Квантуны армийн штабын дарга байсан генерал Итагаки 1936 онд ярихдаа: «Гадаад Монгол нь Зөвлөлтийн Алс Дорнод болон Европын нутгийг холбодог Сибирийн төмөр замын хамгаалалтын жигүүр нь юм. Квантуны армийн зорилго

³ «Вопросы истории», 1951, № 11. стр. 5.

⁴ «Большевик», 1936. № 7. стр. 78.

нь Гадаад Монголд япон-манжийн ноёрхлыг ямар ч аргаар болов тогтооход оршино»⁵ гэжээ.

Ийм түгшүүртэй цаг үед БНМАУ-ын эрх чөлөө, тусгаар тогтнолыг хамгаалах ганц найдвартай баталгаа бол ЗХУ-тай тогтоосон ах дүүгийн найрамдал, цэргийн хамтын ажиллагааг улам бэхжүүлэх явдал байв.

1934 оны 11-р сарын 27-нд манай улсын засгийн газрын хүсэлтээр ЗХУ, БНМАУ-ын хооронд харилцан туслах ам хэлэлцээр байгуулсан юм. Энэ хэлэлцээрээр аль нэгэн гурав дахь орон БНМАУ буюу ЗХУ-д халдан довтолбол харилцан туслаж харилцан дэмжих үүргийг хоёр тал авсан юм.⁶

Японы түрэмгийллийн аюул тулгарсан нэн хүнд үед 1936 оны 3-р сарын 1-нд БХК (б) Намын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга И. В. Сталин америкийн сонин сурвалжлагч Говардын асуултанд хариулахдаа: «Хэрэв Япон БНМАУ-ын тусгаар тогтнолд халдан довтолбол бид БНМАУ-д туслах болно. Бид 1921 онд тусалсны нэгэн адил туслана»⁷ гэж мэдэгдэв. Говард бүр тодорхой лавлан: «Улаанбаатарыг эзлэх гэсэн Японы оролдлого нь ийнхүү ЗХУ-ыг шийдвэртэйгээр хөдөлгөхөд хүргэх үү гэж асуухад нь ерөнхий нарийн бичгийн дарга Тийм ээ. Хүргэнэ» гэжээ.

ЗХУ-ын энэ мэдэгдэл нь Монголын ард түмний хувьсгалт тэмцлийг зоригжуулж Японы милитаристуудад хатуу сануулга болсон юм.

Байдал илэрхий хурцадсан нөхцөлд харилцан туслах ам хэлэлцээрийг протокол гэрээ болгох нь зүйтэй гэж хоёр тал тохиролцов. БНМАУ, ЗХУ-ын хооронд байгуулсан харилцан туслах протокол гэрээнд 1936 оны 3-р сарын 12-нд Улаанбаатарт гарын үсэг зуржээ. Энэхүү протоколд зааснаар хэлэлцээр байгуулсан аль нэг талыг цэргийн хүчээр дайран довтолбол ЗХУ, БНМАУ-ын засгийн газрууд бие биедээ зүйл бүрийн тусламж, түүний дотор цэргийн тусламж харилцан үзүүлэх үүрэг авчээ.⁸

ЗХУ нь харилцан туслах протокол гэрээгээр авсан үүргээ тууштай биелүүлэн БНМАУ-ын хилийг өөрийнхөө хил хязгаар мэт хамгаална гэж зөвлөлт засгийн газар 1939 оны 5-р сард дахин мэдэгдсэн юм.

Зөвлөлт, Монголын харилцан туслах протокол нь манай улсын тусгаар тогтнолыг хамгаалан бэхжүүлэх, ЗХУ, БНМАУ-ын эсрэг үйлдсэн Японы түрэмгийллийг няцаахад шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэв.

2. Халхын голын байлдааны шинж, онцлог

1939 онд Халхын голын районд болсон тулалдаан бол өөрийн шинж байдлын хувьд Японы империалистуудаас ЗХУ, БНМАУ-ын эсрэг явуулсан түрэмгий дайн байсан юм.

1938 онд Японы түрэмгийлэгчид Хасан нуурын орчим ЗХУ-ыг дайран довтолсон боловч бут ниргэгдсэн билээ. Тэд энэхүү ялагдлаас сургамж авахын оронд БНМАУ-ыг эзлэн түрэмгийлэх төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийг оролдсон юм.

ЗХУ-тай харилцан туслах протокол гэрээтэй БНМАУ-д халдан довтолбол зөвлөлтийн цэргийн эсэргүүцэлтэй зайлшгүй тулгарна гэд-

⁵ М. Ю. Рагинский, С. Я. Розенблит. Международный процесс главных японских военных преступников. М., 1950., стр 260.

⁶ «Правда», 1936.III.10.

⁷ Монгол-Зөвлөлтийн харилцааны түүх. УБ., 1981. 95-р тал.

⁸ БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. УБ., 1956. 345-р тал.

гийг Японы милитаристууд сайн мэдэж байв. Гэхдээ тэд өөрсдийн цэргийн хүчийг хэтрүүлэн үнэлж Монгол-Зөвлөлтийн харилцан туслах протокол гэрээний бодит хүчийг дутуу үнэлэн ЗХУ, БНМАУ-ын эсрэг өргөн хэмжээний байлдааны ажиллагаа эхэлсэн юм.

Халхын голын орчим Японы үйлдсэн түрэмгийлэлийн стратегийн зорилго нь БНМАУ-ын тусгаар тогтнолыг устгаж улмаар ЗХУ-д шууд халдан довтолж Сибирийн төмөр замыг огтлон Эрхүүгээс Владивосток хүртэлх Зөвлөлтийн уудам нутгийг эзлэн авах явдал байв.⁹

Энэ төлөвлөгөөг биелүүлэх анхны алхам бол Халхын голын орчим байрласан монгол, зөвлөлтийн цэргийг устгах явдал мөн гэж Японы цэргийн командлал үзсэн юм.

Зохих бэлтгэл хангасны дараа Японы 23-р явган дивизийн цэргүүд 1939 оны 5-р сарын эхээр БНМАУ-ын нутаг дэвсгэрт гэнэт дайран довтолжээ. Ийнхүү Халхын голын тулалдаан эхлэж олон хоног үргэлжилсэн юм.

5-р сарын сүүлчээр Номон хан Бүрд овооны орчим болсон тулалдаанд Японы цэргийн ангиуд бут цохигдсон юм. Гэвч 6-р сард Японы 38 мянган цэрэг өргөн фонтоор давшиж Халхын голын баруун талын Баянцагаан уулыг эзэлсэн юм.

7-р сарын эхээр болсон ширүүн тулалдаанд Зөвлөлт, Монголын дайчид Баянцагаанд нэвтэрсэн дайсны цэргийг устгажээ. Маршал Г. К. Жуковын бичсэнээр «Баянцагааны тулалдаан бол Улаан Цэргийн идэвхтэй хориглолтын сонгодог байлдааны ажиллагаа байв»¹⁰.

Японы командлал хүчээ сэлбэн 8-р сарын эхээр 75 мянган цэрэгтэй 6-р армийн гол хүчээр дахин довтолсон юм. Түүний эсрэг 57 мянган цэрэгтэй зөвлөлт-монголын армийн 1-р групп тулалдав.

Хоёр талаас 80 километрийн өргөн фронтод ийнхүү үлэмж хэмжээний явган, морьт цэргийг хамруулж ялангуяа цэргийн техник «зөвлөлт-монголын талаас 800 танк, хуягт, 500 гаруй нисэх онгоц»-ийг¹¹ өргөн хэрэглэж тулалдсанд Халхын голын байлдааны нэг онцлог оршино. Зарим үед хоёр талаас олон зуун хуягт машин, танк, хэдэн зуун нисэх онгоц нэгэн зэрэг оролцсон тулалдаан болж байв. Энэ чанараараа Халхын голын байлдаан бол дэлхийн хоёрдугаар дайн эхлэхээс өмнөхөн үед нисэх онгоц, танкийн нэгдмэл хүчийг өргөн хэрэглэсэн томоохон тулалдааны нэг байв.

Зөвлөлт, Монголын цэргийн командлал БНМАУ-д халдсан японы түрэмгийлэгчдийг устгах төлөвлөгөөг Зөвлөлтийн гарамгай жанжин Г. К. Жуковын удирдлагын дор боловсруулж маш чадамгай хэрэгжүүлсэн юм. Энэ төлөвлөгөө ёсоор Зөвлөлт, Монголын цэрэг 8-р сарын 24-нд дахин дайралт хийх гэж байсан Японы 6-р армийг өрсөж 8-р сарын 20-нд бүх фронтоор довтолж мөн сарын 28-ныг дуустал үргэлжилсэн тулалдаанд дайсны бүхэл бүтэн армийг бүслэж бүрэн устгажээ.

8-р сарын 29 гэхэд Монгол, Зөвлөлтийн дайчид манай улсын хилийн заагийн дагуу баттай хамгаалалтанд зогссон байв. 1935 онд Японы түрэмгийлэгчдийн булаан эзэлсэн Халхын сүм болон бусад газрыг эргүүлэн авч тус улсын нутаг дэвсгэрийг бүрэн бүтэн болгосон юм.¹²

Халхын голын байлдааны үеэр дайсны 25 мянган цэрэг алагдаж

⁹ «История второй мировой войны». 1939—1945. М., 1980. стр. 167.

¹⁰ Г.К. Жуков. Воспоминания и размышления. М., 1969. стр. 164.

¹¹ БСЭ. № 28., 1978, стр. 176.

¹² МАХН-ын товч түүх. УБ., 1967, 187-р тал.

30 гаруй мянган хүн шархаджээ. Зөвлөлт, Монголын цэрэг японы 660 нисэх онгоцыг сөнөөж байлдааны төрөл бүрийн зэр зэвсэг олзлов.

Урьдчилан тохиролцсон ёсоор хоёр тал 1939 оны 9-р сарын 16-наас эхлэн байлдааны ажиллагааг зогсоосон болно. Ийнхүү дөрвөн сар үргэлжилсэн Халхын голын байлдаан Зөвлөлт, Монголын хамтарсан зэвсэгт хүчний гялалзсан ялалтаар төгсөв. Энэ ялалт бол цэргийн урлагийн гарамгай жишээ мөн.

Японы эрх баригчид дайнд ялагдсанаа нуун дарахын тулд үнэн байдлыг гуйвуулан Халхын голын байлдааныг цэргийн орон нутгийн командлалаас Токиогийн зөвшөөрөлгүй өдүүлсэн хилийн будлиан мэтээр дүрслэхийг оролдож байв. Гэтэл Халхын голын байлдааны үед ерөнхий сайд агсан Хиранума уг байлдааны тухай Японы засгийн газар мэдэж байсныг японы цэргийн гэмт хэрэгтнийг шүүсэн Токиогийн олон улсын таслан шийтгэх хурал дээр хүлээн зөвшөөрчээ.

Японы империалистуудаас ЗХУ, БНМАУ-ын эсрэг Халхын голын орчим үйлдсэн түрэмгийлэл нь зорилт, цар хүрээ, бэлтгэл, оролцуулсан зэвсэгт хүчний хувьд «зарлаагүй дайн» байсан юм гэж олон улсын цэргийн шүүх тодорхойлжээ. Энэхүү түрэмгийллийн хариуцлагыг Японы тэр үеийн засгийн газар бүрэн хүлээнэ.

Халхын голын дайны үеэр империалист Япон бактериологийн зэвсгийг хориглосон Женевийн 1925 онд протоколыг зөрчиж Зөвлөлт, Монголын цэргийн эсрэг бактериологийн зэвсэг хэрэглэснийг тэмдэглэх хэрэгтэй. Хүний ёсноос гадуур энэхүү жигшүүрт гэмт ажиллагааг «731-р тусгай отряд» гэж нэрлэгдсэн маш нууц цэргийн анги гүйцэтгэжээ. Тэрхүү отрядыг ЗХУ-ын эсрэг, түүнчлэн БНМАУ, бусад улсын эсрэг бактериологийн дайн бэлтгэх зорилгоор байгуулсан юм гэж Квантуны армийн ерөнхий командлагч байсан генерал Ямада Японы цэргийн гэмт хэрэгтнийг шүүсэн Токиогийн олон улсын таслан шийтгэх хуралд мэдүүлжээ.

Халхын голын байлдааны үеэр Монгол-Зөвлөлтийн цэргийн эсрэг гэдэсний хижиг, иж балнад, цусан суулгын бактерийн цэнэгтэй зэвсэг хэрэглэснийг 731-р отрядын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга мөн таслан шийтгэх хурал дээр хүлээжээ.¹³ Уг отрядыг удирдаж байсан Исии Сирод Японы командлал талархал илэрхийлжээ.

Японы милитаризм ялагдсаны дараа 731-р отрядын гэмт хэрэгтнүүд америкийн цэргийн командлалын дэмжлэгтэйгээр хариуцлагаас мултарч бактериологийн шинэ зэвсэг үйлдэх ажлаа АНУ-д үргэлжлүүлсэн юм.

Халхын голын ялалт бол Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагаа, дайчин нөхөрлөлийн түүхэнд онцгой чухал суурь эзэлдэг юм. Тус хоёр ард түмэн хувьсгалын жилд бүтээсэн нийгмийн шинэ байгууллага харийн дайснаас хамгаалах хүч чадалтай гэдгээ дэлхий дахинд харуулав. Монгол-Зөвлөлтийн мөнхийн найрамдал Халхын голын тулалдаанд амь үрэгдсэн хоёр орны шилдэг хөвгүүдийн ариун цусаар улам батжин гагнагдсан юм.

Энэ ялалт бол Зөвлөлт, Монголын цэргийн хамтын ажиллагаа, зэвсэгт хүчний нэгдэл нягтралын үр дүн юм. Зөвлөлтийн дайчид ин-

¹³ Материалы судебного процесса по делу бывших военнопленных Японской армин, обвиняемых в подготовке и применении бактериологического оружия М., 1950, стр. 9, 62.

¹⁴ «Новое время» 1982, № 36. стр 28.

тернационалч үүргээ нэр төртэй биелүүлж манай ард түмний хувьсгалаар байлдан олсон бүхий л ололтыг авран хамгаалсан юм.

Зөвлөлт, Монголын цэргийн нэгдсэн хүчийг командалсан Георгий Константинович Жуков Халхын голын ялалтанд асар их хувь нэмэр оруулсан юм. ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар маршал Г. К. Жуков, ЗХУ-ын хоёр удаагийн баатар Я. В. Смушкевич, С. И. Грицевец, Г. П. Кравченко, ЗХУ-ын баатар М. П. Яковлев, И. М. Ремизов, И. И. Федюнинский нарын зэрэг зөвлөлтийн ард түмний олон хөвгүүдийн байгуулсан гавьяа БНМАУ-ын түүхэнд үүрд дурсагдан мөнхжих болно. Зэвсэг нэгтэй Зөвлөлтийн анд нөхөдтэйгээ мөр зэрэгцэн тулалдсан БНМАУ-ын баатар Л. Дандар, Ц. Олзвой, Л. Гэлэгбаатар нарын зэрэг Монголын олон зоригтныг Халхын голын байлдаан тодруулав. БНМАУ-ын бүх цэргийн жанжин маршал Х.Чойбалсан ялалтыг зохион байгуулахад биечлэн оролцсон болно.

Халхын голын ялалт Зөвлөлт, Монголын дайчдын улс төрийн өндөр ухамсар, зан суртахууны давуу чанарыг яруу тод харуулав. Тэд бүхэл бүтэн анги, нэгтгэлээрээ баатарлаг тулалдах явдал ердийн үзэгдэл болжээ. Гэтэл Япон цэрэг сэтгэл санааны уналтанд орж тэднийг архи уулган согтоох буюу пулемёт, танканд нь гинжээр холбох зэрэг арга хэрэглэн байлдуулах тохиолдол ч гарч байв. Манжгогийн цэрэгт дайчлагдсан өвөр монголчууд олноороо Зөвлөлт, Монголын цэрэгт сайн дураараа буун өгч зарим нь фронтоос оргон зайлаад Японы түрэмгийлэгчдийн ар талд партизаны отряд байгуулан тулалдаж байв. Энэ бүхэн Японы эзлэсэн нутагт тогтоосон колонийн ёс дэглэм батгүй болохыг гэрчилж байв.

Халхын голын байлдаан Монголын хувьсгалт засаг төрийн бат бэхийг, мөн фронт, ар талын бат нэгдлийг харуулав. Сайн дураар цэрэгт элсэх, байлдаж буй армид хоол хүнс нийлүүлэх, бэлэг явуулах эх оронч хөдөлгөөн орон даяар өрнөв.

Манай ардын цэргийн ангиудад намын байгууллага өсөн бэхжиж, МАХН-ын гишүүд, цэргийн улс төрийн ажилтнууд галын шугамд баатарлагаар тулалдахын үлгэр жишээ үзүүлж байв.

МАХН марксизм-ленинизм, пролетарийн интернационализмыг удирдлага болгосноороо Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийг хангах үндсэн нөхцөл бүрдүүлснийг Халхын голын ялалт хөдөлшгүй нотолжээ.

3. Халхын голын ялалтын олон улсын ач холбогдол

Халхын голын ялалт олон улсын асар их ач холбогдолтой үйл явдал байв. Энэ бол дэлхийн империалист харгислалын нэг гол отряд-Японы түрэмгийлэгчдийг социалист ертөнцийн зэвсэгт хүчин ялсан алдарт ялалт болсон юм. Халхын голын ялалтын үр дүн олон улсын нийт байдалд нөлөөлсөн юм.

Нэгд. Халхын голын дайн бол нэг талаас социалист замаар хөгжсөн анхны хоёр улс, нөгөө талаас капитализмын хамгийн харгис хүчний хооронд болсон цэргийн халз мөргөлдөөн байв. Энэ тулалдаанд социализмын хүч ялсан нь дэлхийн харгислалд хатуу цохилт болж, Ази, Алс Дорнодод империализмын эсрэг хүчний байр суурийг бэхжүүлэхэд тус дөхөм үзүүлсэн юм.

Ардын эрхт Монгол улс ЗХУ-ын тусламжтайгаар тусгаар тогтнолоо хамгаалж чадсан нь ялангуяа Азийн улс түмэнд хувьсгалжуулагч гүнзгий нөлөө үзүүлэв.

Хоёрт. Халхын голын ялалт Монгол - Зөвлөлтийн найрамдал, хамтын ажиллагааны аугаа их хүч чадал, түүний олон улсын ач холбогдлыг дэлхий дахинд харуулав. ЗХУ-аас манай улсад үзүүлсэн цэргийн тусламж бол пролетарийн интернационализмын тодорхой биелэл мөн. ЗХУ, БНМАУ-ын дайчин холбоо нь Ази, Алс Дорнодод империалист түрэмгийллийг няцаах, энх тайвныг сахин хамгаалах үр нөлөөтэй хүчин зүйл мөн гэдгээ гэрчлэв.

Гуравт. Халхын голд ялагдсаны дараа Япон 1941 оны 4-р сард ЗХУ-тай төвийг сахих тухай гэрээ байгуулахад хүрсэн юм. Уг гэрээнд хавсаргасан тунхаглалаар Япон улс «Бүгд Найрамдах Монгол Ард Улсын нутгийн бүрэн бүтэн бөгөөд халдашгүй байдлыг хүндэтгэх» үүрэг авчээ.¹⁵ Халхын голын ялалт нь ЗХУ, БНМАУ-ын эсрэг Японы түрэмгийллийг хэдэн жилээр саатуулж чадсан юм. Энэ хугацаанд олон улсын байдалд энх тайван, социализмын хүчинд ашигтай үндсэн өөрчлөлт гарсан билээ.

Дөрөвт. Халхын голын ялалт нь Японы түрэмгийллийг ЗХУ-ын зүгт хандуулах зорилготой Өрнөдийн гүрнүүдийн «Алс Дорнодын Мюнхений» бодлогыг нураахын зэрэгцээ Японыг фашист Германтай нэгэн зэрэг ЗХУ-ын эсрэг дайнд татаж оруулахыг эрмэлзэж байсан Гитлерийн төлөвлөгөөг бас нураажээ.

Тавд. Японы эзэн хааны цэргийн шигшмэл хэсгийг Халхын голд хиар цохисон юм. Зөвлөлт, Монголын дайчдын ялалт Японы цэрэг ялагдашгүй гэсэн домгийг няцааж Японы түрэмгийлэгчидтэй тэмцсэн Азийн улс түмнийг зоригжуулсан юм.

Зургаад. Маршал Г. К. Жуковын бичсэнээр «Халхын голын тулалдаан бол байлдааны туршлагын томоохон сургууль болсон юм». Энэ туршлага нь ЗХУ-ын зэвсэгт хүчний бэлтгэл, бүтэц бүрэлдэхүүн, байлдааны техникийг боловсронгуй болгоход тусалснаараа гитлерийн Германыг бутцохиж Европын улс түмнийг фашизмын боолчлолоос лөөлөхөд ихээхэн тус нэмэр болжээ.

Халхын голын ялалтын олон улсын ач холбогдлыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрчээ. Янз бүрийн үзэл бодлоготой Өрнөдийн шинжээч, түүхчдийн санал, дүгнэлт ч гэсэн үүнийг нотлон харуулж байна.

ЗХУ-тай том дайн дэгдээвэл балран сүйрнэ гэдгийг Халхын гол япончуудад харуулсан юм гэж америкийн шинжээч Дж. Макшерри бичсэн байна.¹⁶

Герман 1941 оны 6-р сард ЗХУ-д дайран довтолох үед Японы засгийн газраас түүнтэй нийлэхгүй шийдвэр гаргахад Халхын голын ялалт нөлөөлөв гэсэн дүгнэлтийг Английн түүхч М. Макинтош хийжээ.¹⁷

Монголч эрдэмтэн О. Латтимор (АНУ): Япончууд Халхын голын районоор дайран довтолж Монгол, Зөвлөлтийн харилцаа холбооны бат бэхийг туршсаны дүнд сүйртлээ ялагдсан юм. 1939 оны олон улсын байдалтай холбож үзвэл энэ байлдаан нэн чухал ач холбогдолтой байв. Хэрэв япончууд амжилт олсон бол тулгаран ойртож байсан дэлхийн хоёрдугаар дайны бүхий л шинж байдал нь өөр болсон байж магадгүй юм гэж Халхын голын ялалтын ач холбогдлыг үнэлжээ.¹⁸

Ази, Алс Дорнодын асуудлыг судалдаг О. Клабб (АНУ): «Номон Ханы (Халхын голын--Ц.П.) тулалдаан бол түүхэнд шийдвэрлэгч

¹⁵ «Үнэн», 1941.IV.15. № 41.

¹⁶ История второй мировой войны. М., 1980. стр. 168.

¹⁷ Мөн тэнд.

¹⁸ Owen Lattimore. Nomads and Commissars. N. Y. 1962. p. 134—135.

эргэлт гаргадаг үйл явдлын нэг мөн гэдгээ гэрчлэв. Тэр нь ЗХУ-тай дайтахыг урьдал болгож байсан Японы бүлгийг ялагдахад хүргэж далайн гүрнүүдтэй мөргөлдөх стратеги баримтлагчдыг Японы засгийн газарт давамгайлах болгожээ»¹⁹ гэж дүгнэсэн байна.

БНМАУ-ын орчин үеийн түүхийг социализмын эсрэг үзлийн үүднээс гуйвуулан бичсэн Бауден (Англи) хүртэл Халхын голын байлдааны ач холбогдлыг үгүйсгэж чадахгүй, түүнийг Зөвлөлт--Монголын хамтарсан хүчний «шийдвэрлэгч ялалт»²⁰ мөн гэж үзсэн байна.

Мөн Английн судлаач Чэйни маршал Г. К. Жуковын тухай бичсэн номдоо «Халхын голын байлдаанаас Японы эрх баригчид гашуун сургамж авсан юм. Тэд Зөвлөлтийн зэвсэгт хүчин, нэн ялангуяа их буу, хуягт, танкийн талаар Японы армиас хол давуу болохыг аргагүй эрхэнд хүлээн зөвшөөрөхөд хүрчээ»²¹ гэжээ.

Харин Японы эрх баригчид Халхын голын байлдаанд ялагдсанаа ард түмнээсээ нуухыг оролдсон боловч дайны дараах жилд үнэн байдлыг илчилсэн нэлээд баримт материал хэвлэгдэн гарсан болно.

АНУ-ын эрх баригчдын зэвсэглэлээр хөөцөлдөх, социалист орнууд болон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эсрэг чиглэсэн түрэмгий бодлогын уршгаар олон улсын байдал хурцдаж Алс Дорнодод Японы милитаризм дахин сэргэж байгаа өнөөгийн нөхцөлд Халхын голын сургамж цаг үеийн чухал ач холбогдолтой болж байна. Өнөөгийн үйл явдлыг гүнзгий ойлгохын тулд өнгөрснийг эргэн санах хэрэгтэй.

Азид ноёрхох, нэн ялангуяа ЗХУ болон манай улсад халдан довтлох гэсэн милитарист үзэл санаа Японд амь бөхтэй оршсоор ирснийг түүх гэрчилж байна. Халхын голд бут ниргэгдсэнийхээ дараа ч гэсэн Японы эрх баригчид ЗХУ, БНМАУ-ын эсрэг шинэ түрэмгий дайнд бэлтгэж байв. 1941 оны 7-р сарын 2-нд эзэн хаан Хирохито оролцсон Японы төрийн зүтгэлтний нууц зөвлөлгөөнөөс ЗХУ-ын талаар явуулах бодлогыг тодорхойлохдоо: «Герман-Зөвлөлтийн дайны явц Японд ашигтайгаар өөрчлөгдвөл бид Умардын асуудлыг шийдвэрлэхийн тулд зэвсэг хэрэглэнэ» гэжээ.

Зөвлөлгөөний шийдвэр ёсоор ЗХУ-ыг дайран довтлох «Кантокуэн» (Квантуны армийн цэргийн тусгай сургууль) гэдэг нэртэй нууц төлөвлөгөөг зохиожээ.

Гагцхүү гитлерийн Германы цэргийг эхлээд Москвагийн орчим, дараа нь Сталинградын дэргэд бут цохиж дайны явц ЗХУ-д ашигтайгаар өөрчлөгдсөн нь Японы түрэмгий төлөвлөгөөг эвдсэн юм. ЗХУ эх орны аугаа их дайны үед 40 хүртэл дивизийг Алс Дорнодын хил хязгаартаа барьж байхад хүрснээр милитарист Японы эрх баригчид гитлерийн Германд биетэй дэмжлэг үзүүлсэн болно.

ЗХУ БНМАУ-ын оролцоотойгоор империалист Японыг бут ниргэсний үр дүнд Ази дахь хүчний харьцаа энх тайван, социализмын хүчинд ашигтайгаар өөрчлөгдсөн билээ. Ази тивд үндэсний эрх чөлөөний тэмцэл бадарч империализмын колонийн систем задран унав. Харин одоо АНУ-ын дэмжлэгтэйгээр Японы милитаризм өндийн босч байгаа нь хувьсгалт, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний эдгээр ололт болон дэлхийн хоёрдугаар дайны үед Японы түрэмгийлэлд нэрвэгдсэн Азийн олон орны аюулгүй байдалд заналхийлж байна.

¹⁹ O. Edmund Clubb. China and Russia. N. Y. 1971. p. 318,

²⁰ C. R. Bawden. The Modern history of Mongolia. N. Y. –Washington. 1968. p. 329.

²¹ Otto Preston Chaney Zhukov. London, 1972. p. 58

Өнөөгийн Япон улсын эрх баригчид ЗХУ, социалист орнуудын эсрэг хандсан АНУ-ын стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож цэргийн потенциалгаа нэмэгдүүлэх, өөрийн орны нутаг дэвсгэрийг дайн түрэмгийллийн түшиц газар болгох, АНУ-ын дунд зайны цөмийн пуужин байрлуулах, АНУ, жанжлагчид болон Азийн харгис дэглэмүүдтэй цэрэг-улс төрийн холбоо байгуулах бодлого явуулж байгаа нь энхийг эрхэмлэгч хүчний сонор сэрэмжийг дээшлүүлэхийг шаардаж байна. Японы монополиуд Азийн орнуудад идэвхтэй нэвтэрч энэ тивд дангаараа ноёрхох гэсэн дээр үеийн төлөвлөгөөгөө сэргээх урьдчилсан нөхцөлийг бий болгохыг оролдож байгааг анхаарахгүй өнгөрч болохгүй юм.

Японыг милитаризмын замд түлхэж байгаа харгис хүчин залуу үеийг шовинист, милитарист үзлээр хүмүүжүүлэх, Японы эзэн хааны армийн хийсэн эзлэн түрэмгийлэх дайныг түүхийн үүднээс зөвтгөхийн хамт дэлхийн II дайны үр дүнг хянан үзэх, хонзогногч элдэв шаардлага тавьж байна. Тэд түрэмгий бодлогоо үзэл суртлын хувьд шинэ арга хэлбэрээр үндэслэхийн тулд Азид Японы ноёрхох байр суурийг хангах зорилготой «Номхон далайн хамтлаг» байгуулах үзэл санааг идэвхтэй сурталчилж байна.²²

Японд болж байгаа өнөөгийн үйл явдлууд, түүний улс төрийн бодлогын ерөнхий хандлага нь 30—40-өөд оныг санагдуулж байна. Японы эрх баригчид чухамдаа японы самурай нарын эзлэн түрэмгийлэх бодлогын хуучин үндэслэлийг шинэ нөхцөлд тохируулан хэрэглэж байна.

Гэвч орчин цагт улс түмнийг эзлэн түрэмгийлэх гэсэн бодлого явцгүй болсон юм. Социализмын замаар хөгжсөн орнуудыг дайн түрэмгийллийн аргаар устгах гэсэн Японы эрх баригчдын санаа бүтэшгүй гэдгийг Халхын голын ялалт 45 жилийн өмнө нотолсон билээ.

Өнгөрсөн хугацаанд дэлхий ертөнц үндсээрээ өөрчлөгдөв. ЗХУ болон социалист нөхөрлөлийн орнуудын найрамдал, хамтын ажиллагаа, батлан хамгаалах хүч чадал нь дэлхийн социалист системийн ололтыг найдвартай хамгаалж байна. Хэрэв түүхийн сургамжийг эс ойшоовол чухам юунд хүрч болохыг Халхын голын туршлага түрэмгийлэгчдэд сануулж байна.

ХАЛХИНГОЛЬСКАЯ ПОБЕДА И ЕЁ МЕЖДУНАРОДНОЕ ЗНАЧЕНИЕ

(Р е з ю м е)

Правящие круги Японии в интересах монополистического капитала своей страны с давних времен стремились захватить Монголию и после победы Великой Октябрьской социалистической революции превратить её территорию в плацдарм для войны против первого в мире социалистического государства рабочих и крестьян—СССР.

В поисках путей выхода из тяжелого экономического кризиса,

²² «Проблемы Дальнего Востока», 1982, № 1. стр. 95

охватившего Японию в начале 30-х годов, правящие круги этой страны выбрали метод внешней авантюры. Захватив Маньчжурию в сентябре 1931 года и создав там марионеточное государство «Маньчжоу-Го», милитаристская Япония стала непосредственным соседом МНР и угрожать её независимости. Наряду с этим Япония, заключив «антикоминтерновский пакт» с гитлеровской Германией и фашистской Италией, подготовила захватническую войну против СССР и стала очагом войны на Дальнем Востоке. В агрессивных планах японской военщины, нашедших свое яркое выражение в меморандуме Танака (1927 г.), важное место отводилось ею захвату Монгольской Народной Республики.

В статье автор, опираясь на фактические материалы, освещает характер и особенности жестоких кровопролитных халхингольских боев, продолжавшихся с начала мая до середины сентября 1939 года между советско-монгольскими и японо-маньчжурскими войсками в тесной связи с международной обстановкой того времени, в частности положением на Дальнем Востоке. По мнению автора статьи, нападение японской военщины на МНР в районе реки Халхин-гол в 1939 году по характеру и целям, по количеству войск и боевой техники, введенных в поле боя, по масштабам военных операций было необъявленной агрессивной войной Японии против МНР.

В этот трудный момент Советский Союз в соответствии с Протоколом о взаимной помощи между МНР и СССР от 1936 года, выполняя свои союзнические обязательства и интернациональный долг, сказал нашей стране решительную военную помощь. Военной операцией советско-монгольских войск по разгрому японских захватчиков руководил на месте талантливейший советский военачальник Г. К. Жуков. Командование советско-монгольских войск тщательно разработало план окружения и уничтожения вторгшихся в нашу страну японских самураев, который начал осуществляться с наступлением советско-монгольских войск с 20 августа 1939 года. В результате боевых действий советско-монгольских войск в короткий срок 6-я императорская армия Японии была окружена и уничтожена и оккупированная японцами часть территории МНР была полностью очищена от японских захватчиков.

Потерпев поражение, правительство Японии запросило начать переговоры о прекращении огня и на основе взаимной договоренности с 16 сентября 1939 года прекратились военные действия с обеих сторон и был восстановлен мир на монголо-маньчжурской границе.

Победа советско-монгольских войск на реке Халхин-гол занимает особое место в истории братских взаимоотношений и боевого содружества монгольского и советского народов и их армий. Она продемонстрировала перед всем миром силу и прочность нерушимой дружбы и тесного сотрудничества наших двух народов и их армий достойно защищать на поле брани завоевания социализма от посягательств чужеземных захватчиков. Военная помощь СССР нашей стране явилась конкретным воплощением пролетарского, социалистического интернационализма в действии. МНР с помощью СССР сумела отстаивать свою свободу и государственную независимость от злейшего врага-японской военщины и обеспечить свое мирное развитие и процветание по пути строительства нового общества.

Далее автором статьи затрагивается вопрос о международном значении победы на реке Халхин-гол. Историческая победа советско-

монгольских войск в районе реки Халхин-гол, как подчеркивает автор, была славной победой вооруженных сил социалистического мира над японской военщиной, являвшейся тогда одним из главных отрядов блока агрессивных фашистских государств и пользовавшейся поддержкой всей международной империалистической реакции. Победа сил социализма в этом вооруженном столкновении не только развеяла агрессивные планы японского милитаризма, но и одновременно распутала расчеты всей международной империалистической реакции. Она вдохновляла освободительные силы Азии и Дальнего Востока на активизацию своей борьбы против сил войны и фашизма, реакции и империализма.

Эта победа заметно повлияла на всю международную обстановку того времени и в последующем. Проиграв бои у реки Халхин-гол, японский милитаризм не осмелился вступить в войну против СССР одновременно с фашистской Германией и был вынужден соблюдать Пакт о нейтралитете, подписанный между СССР и Японией 13 апреля 1941 года, хотя и он часто нарушал его статьи. И это обстоятельство использовалось силами мира и социализма изменение международной обстановки в свою пользу.

В заключительной части статьи автор подвергает критике крайне опасную политику нынешних правящих кругов Японии по возрождению японского милитаризма, которые по прямому указанию Администрации США в союзе с реакционным сеульским режимом, со странами НАТО и силой гегемонизма форсируют военные приготовления против СССР и других стран мирового социализма, превращают свою страну в площадку для размещения ракетно-ядерного оружия первого удара военных стратегов американского империализма. Эта политика нынешних правящих кругов Японии, как подчеркивает автор, вольно или невольно напоминает политику японских самураев в 30—40-х годах, только приспособленную к современному положению в мире. Если агрессивные милитаристские круги международной империалистической реакции вопреки горьким урокам истории встанут на путь военных авантур против СССР и других стран социалистического содружества, то они, как заключает автор, постигнут такую же участь, самураи на войне у реки Халхин-гол и фашистская Германия во второй мировой войне. Следовательно, победа советско-монгольских войск в 1939 году на реке Халхин-гол и в наши дни является серьезным предупреждением для любого возможного агрессора из сил империализма и военных авантур.